



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2025 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Татан буулгах комисс байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний хуулийн 32 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолын 3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан эд хөрөнгө, архив, албан хэргийн материалыг хүлээн авч бүртгэх, хуулийн этгээдийг татан буулгахтай холбогдон үүсэх бусад асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх үүрэг бүхий татан буулгах комиссыг 1 дүгээр хавсралтаар байгуулсугай.

2. Татан буулгах комиссын ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Татан буулгах ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулахыг Татан буулгах комисс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132003299

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
даргын 2025 оны 10 дүгээр сарын 24-ны өдрийн  
А/дугаар тушаалын 1 дүгээр хавсралт




ТАТАН БУУЛГАХ КОМИССЫН БҮРЭЛДӨХҮҮН

Ахлагч	Ц.Баяр-Эрдэнэ	/Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга/
Гишүүд:	В.Батчимэг	/Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, зөвшилцсөнөөр/
	Г.Одгэрэл	/Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/
	С.Амарсанаа	/"Аялал жуулчлалын хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий нягтлан бодогч, зөвшилцсөнөөр/
Нарийн бичиг:	Б.Билгүтэ	/Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн/
	М.Гантулга	/ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, зөвшилцсөнөөр /

----- о О о -----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
даргын 2025 оны 10... дүгээр сарын 24-ны өдрийн  
4/35 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



## ТАТАН БУУЛГАХ КОМИССЫН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

### Нэг: Зорилго.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 61 дүгээр тогтоолын 1-т заасны дагуу “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгах ажлын хүрээнд Татан буулгах комисс энэхүү удирдамжийг баримтална.

### Хоёр: Хийгдэх ажлын чиглэл.

1. Үйлдвэрийн газрыг татан буулгах тухай мэдэгдлийг нийтэд мэдээлэх;
2. Үйлдвэрийн газрыг татан буулгах, нэхэмжлэл гаргах журам, хугацааг зээлдүүлэгчид бичгээр мэдэгдэх;
3. Үндсэн болон эргэлтийн хөрөнгөд тооллого хийж, акт үйлдэн хүлээн авах;
4. Төсвийн болон бусад өр төлбөр, ажиллагсадтай хийх өр, авлагын тооцоог нэгтгэн гаргаж, барагдуулах арга хэмжээ авах;
5. Архив, албан хэргийн материалыг акт үйлдэн Архивын ерөнхий газар хүлээлгэн өгөх;
6. Санхүүгийн хаалтын тайлан тэнцэл гаргах;
7. Холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдийг улсын бүртгэлийн байгууллагад татан буулгах талаар мэдэгдэж, улсын бүртгэлээс хасуулах.

### Гурав: Хугацаа, үр дүн.

Татан буулгах комисс “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан шийдвэрлэх.

----- о О о -----